



## ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Энхтайваны гудамж 136, Утас: 7012 8801,  
Факс: (976) 32 06 33, И-мэйл: admin@hdc.gov.mn,  
Вэбсайт: www.hdc.gov.mn

2020-11-06 № 1888  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ НАРТ

Шинэ төрлийн коронавируст халдвар (ковид-19)-ын эрсдэлээс хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хүн амыг өвдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор байгуулсан эрүүл мэндийг дэмжих төвүүдэд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийг нийлүүлэх тендерийн үнийн санал авах баримт бичигт өөрчлөлт оруулах болсныг үүгээр мэдэгдэж байна.

ЗАХИРАЛ  Б.НАРАНТУЯА



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

ЗАХИРАЛ



БАТЛАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
Б.НАРАНТУЯА

Огноо: 2020.11.06

**ШИНЭ ТӨРЛИЙН КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ХАЛДВАРЫН  
ЭРСДЭЛЭЭС ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ, ХҮН АМЫГ ӨВДӨХӨӨС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ТӨВҮҮДЭД  
ШААРДЛАГАТАЙ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ НИЙЛҮҮЛЭХ  
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр:** Шинэ төрлийн коронавируст халдвар (ковид-19)-ын эрсдэлээс хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хүн амыг өвдөхөөс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийг дэмжих төвүүдэд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийг нийлүүлэх

**Төслийн дугаар:** ЭМХТ-20201106/04

УЛААНБААТАР ХОТ  
2020 он

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |  |
|---|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.<br>2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br><br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]   |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.   |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.  |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь *ТШӨХ-д* заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

| <b>ТӨӨЗ-ны холбогдох заалт</b> | <b>Шалгуур үзүүлэлт</b>   |
|--------------------------------|---|
| ТӨӨЗ 1.1                       | <p><b>Захиалагч, төсөл арга хэмжээний нэр: ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ.</b><br/>                     Шинэ төрлийн коронавируст халдвар (ковид-19)-ын халдварын эрсдлээс хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хүн амыг өвдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор байгуулж буй эрүүл мэндийг дэмжих төвүүдэд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх<br/> <b>Тендерийн дугаар: ЭМХТ-20201106/04</b><br/> <b>Санхүүжилтийн эх үүсвэр: Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2020 оны урсгал төсөв</b></p>  |
| ТӨӨЗ 1.1                       | <p>2018, 2019 болон 2020 оны эхний хагас жилд тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй барааг нэг удаагийн гэрээгээр нийлүүлсэн байх бөгөөд гэрээ, хүлээлгэн өгсөн акт, захиалагч байгууллагын тодорхойлолтын хамт ирүүлнэ.</p>  |
| ТӨӨЗ 2.1                       | <p><b>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</b><br/> <b>Огноо: 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр</b><br/> <b>Цаг: 14 цаг 30 минут</b><br/>                     Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй.<br/>                     Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.<br/> <b>Тендер хүлээн авах этгээд:</b> Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгийг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.<br/>                     Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө тендерээ электрон хэлбэрээр буюу "PDF" форматаар гаргацтай, тод хөрвүүлж илгээх, ингэхдээ өөрийн санал болгож буй тендерийн үнэ, хүчинтэй хугацаа болон холбогдох бусад мэдээллийг системийн холбогдох талбарт бүрэн оруулсан байх зэрэг хуулийн 53.5.4-т заасны дагуу мэргэжлийн байгууллагаас тогтоосон бусад аргачлал, зааврыг баримталж тендер илгээх;<br/>                     Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50 000 (тавин мянга) төгрөгийг ЭМХТ, Төрийн сан банк 100900020405 тоот данс /РД:9086331/ -д төлсөн байх ёстой.</p> |
| ТӨӨЗ 2.1                       | <p><b>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</b><br/>                     2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 14 цаг 30 минут. Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 3 давхрын хурлын танхимд нээнэ.</p>   |

|                        |  |
|------------------------|--|
| <p><b>ТӨЭЗ 2.3</b></p> | <p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Монгол улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрийг тендер нээсэн тухайн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна.</li> <li>2. Цахим систем, Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн сангаас тендерт оролцогчдын татвар төлөлтийн байдлыг тендер нээсэн өдрийн байдлаар шалгана.</li> <li>3. Үнийн хуваарь болон бараа нийлүүлэлтийн хуваарийг баталгаажуулан ирүүлнэ.</li> <li>4. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ.</li> <li>5. Тусгай зөвшөөрөл: Эмнэлгийн тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх, худалдах тусгай зөвшөөрлийн хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлэх шаардлагатай.</li> <li>6. Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтааж бараа захиалагчид нийлүүлэх баталгааг бичгээр ирүүлнэ.</li> <li>7. Ижил төстэй бараа, ажил, үйлчилгээ гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 2018, 2019 болон 2020 оны эхний хагас жилд тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас доошгүй үнийн дүнтэй барааг нэг удаагийн гэрээгээр нийлүүлсэн байх бөгөөд гэрээ хүлээлгэн өгсөн акт ирүүлнэ.</li> <li>8. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх бөгөөд харилцагч банкны дансны үлдэгдлийн тодорхойлолт, шугаман зээлийн эрхийн үлдэгдлийн тодорхойлолтоор тооцно. Судлан үзэх болон шалгарсан тохиолдолд олгох боломжтой тухай тодорхойлолтыг тооцохгүй.</li> <li>9. Гэрээг гүйцэтгэх байгууллага нь үндсэн ажилтан болох 2-оос доошгүй эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженертэй байх бөгөөд инженерийн чадвар, мэргэжлийг илтгэх боловсролын диплом, үнэмлэхийн хуулбар болон сүүлийн 12 сарын НД-8 лавлагааг ТҮЦ машинаас авсан байдлаар ирүүлнэ.</li> <li>10. Бараа нь технологийн хувьд орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан, ашиглахад энгийн, ажиллагааг хянах боломжтой, олон улсын бүтээгдэхүүний чанарын CE, FDA, ISO, TUV зэрэг стандартуудын аль нэгийг хангасан байх бөгөөд холбогдох чанарын сертификатыг ирүүлнэ. Тухайн тоног төхөөрөмжийг ашиглахад шаардлагатай бүх нэмэлт болон дагалдах хэрэгслүүдийг хамтад нь санал болгосон байна.</li> <li>11. Нийлүүлэх тоног төхөөрөмжийн зураг, каталогийг ирүүлнэ.</li> <li>12. Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл эсвэл албан ёсны төлөөлөгч болохыг нотолсон баримт бичгийг баталгаат орчуулгын хамт ирүүлнэ.</li> <li>13. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагыг үндсэнд нь хангаж байгааг нотолсон мэдэгдэл, техникийн тодорхойлолттой харьцуулсан хүснэгтийг ирүүлнэ. Нийцлийн хүснэгтийг үйлдвэрлэгчийн албан ёсны веб хуудасны каталогтой тулгаж үзнэ.</li> <li>14. Хавсралтаар өгөгдсөн техникийн тодорхойлолтод заасан бүх шаардлагуудыг хангасан байна.</li> </ol> |
| <p><b>ТӨЭЗ 6.2</b></p> | <p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p>Багц 1. Ачаалалтай зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, ЭМХТ-20201106/04-01</p> <p>Багц 2. Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, ЭМХТ-20201106/04-02</p> <p>Багц 3. Холтер /бичигчтэй/, ЭМХТ-20201106/04-03</p> <p>Багц 4. Нүдний хараа шалгах таблиц, ЭМХТ-20201106/04-04</p> <p>Багц 5. Слит ламп /биомикроскоп/, ЭМХТ-20201106/04-05</p> <p>Багц 6. Авторефракто/кератометр, ЭМХТ-20201106/04-06</p> <p><b>Оролцогч нэг эсхүл хэд хэдэн багцад тендер ирүүлж болно.</b></p>   |

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** [Барааны тодорхойлолт, техникийн үзүүлэлтийг энд бичнэ.]
2. **Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл [Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.] гэж бичнэ
3. **Баглаа, боодол:** [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Баглаа боодлын нөхцөлийг цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, далайгаар тээвэрлэх тохиолдолд хөлөг онгоцны тавцан дээр, эсхүл доор тээвэрлэх зэргийг харгалзаж тодорхойлно. Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.]
4. **Бараа хүргэх газар:** [Барааг хүлээж авах хаягийг бичнэ]
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

| № | Тодорхойлолт                                   | Тоо ширхэг | Хэмжих нэгж | ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг                                | Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа |                          |                                      |
|---|--|------------|-------------|---|---|--------------------------|--------------------------------------|
|   |  |            |             |   | Нийлүүлэх хамгийн эхний хугацаа                               | Нийлүүлэх эцсийн хугацаа | Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа |
| 1 | 2  | 3          | 4           | 5   | 6   | 7                        | 8                                    |
| 1 | Ачаалалтай зүрхний цахилгаан бичлэгийн аппарат | 5          | ш           | СХДЭМТ, БЗДНЭМТ, Өвөрхангай аймгийн БОЭТ, Увс аймгийн Нэгдсэн эмнэлэг | 20 хоног  | 30 хоног                 |                                      |
| 2 | Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат            | 10         | ш           | СХДЭМТ, БЗДНЭМТ, Өвөрхангай аймгийн БОЭТ, Увс аймгийн Нэгдсэн эмнэлэг | 20 хоног  | 30 хоног                 |                                      |
| 3 | Холтер /бичигчтэй/                             | 5          | ш           | СХДЭМТ, БЗДНЭМТ, Өвөрхангай аймгийн БОЭТ, Увс аймгийн Нэгдсэн эмнэлэг | 20 хоног  | 30 хоног                 |                                      |
| 4 | Нүдний хараа шалгах таблиц                     | 5          | ш           | СХДЭМТ, БЗДНЭМТ, Өвөрхангай аймгийн БОЭТ, Увс аймгийн Нэгдсэн эмнэлэг | 20 хоног  | 30 хоног                 |                                      |

|   |                             |   |   |  |          |          |  |
|---|-----------------------------|---|---|--|----------|----------|--|
| 5 | Слит ламп<br>/биомикроскоп/ | 5 | ш | СХДЭМТ,<br>БЗДНЭМТ,<br>Өвөрхангай<br>аймгийн БОЭТ,<br>Увс аймгийн<br>Нэгдсэн эмнэлэг | 20 хоног | 30 хоног |  |
| 6 | Авторефракто<br>/кератометр | 5 | ш | СХДЭМТ,<br>БЗДНЭМТ,<br>Өвөрхангай<br>аймгийн БОЭТ,<br>Увс аймгийн<br>Нэгдсэн эмнэлэг | 20 хоног | 30 хоног |  |



Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл          | Тодорхойлолт | Барааны гарал үүслийн улс | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|--------------------|--------------|---------------------------|------------|----------|----------|-------------------------------|----------|
| 1                  | 2            | 3                         | 4          | 5        | 6        | 7                             | 8        |
|                    |              |                           |            |          |          |                               |          |
|                    |              |                           |            |          |          |                               |          |
| Тендерийн нийт үнэ |              |                           |            |          |          |                               |          |

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

**2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО  
ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч,<br>холбоо барих<br>хаяг /утас/<br>факс | Гэрээний үнийн<br>дүн | Гэрээний эхлэх<br>хугацаа | Гэрээний<br>дуусах хугацаа |
|--------------|---|-----------------------|---------------------------|----------------------------|
| 1.           |   |                       |                           |                            |
| 2.           |   |                       |                           |                            |
| 3.           |   |                       |                           |                            |
| 4.           |   |                       |                           |                            |
| 5.           |   |                       |                           |                            |
| бусад.       |   |                       |                           |                            |

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна.  |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ.   |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]<br>Баталгаат засварын хугацаанд хийх техник үйлчилгээг тогтмол 3 ба 6 сар тутам эсвэл тухайн төхөөрөмжийн гарын авлагат заасан графикийн дагуу техник үйлчилгээ хийх ба тоног төхөөрөмж гэмтэл гарсан тохиолдолд 24-72 цагийн дотор засвар үйлчилгээг хийж гүйцэтгэн хэвийн ажиллагаанд оруулна.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br><br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;<br>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;<br>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;<br>5) барааны гарал үүслийн гэрчилгээ.<br><br>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.<br><br>2.2. <b>Баталгаат засварын тусгай шаардлага:</b> Тоног төхөөрөмжийн ашиглалтын талаарх сургалтыг хангалтгүй хийсний улмаас хэрэглэгчийн гаргасан гэмтлийг тухайн ханган нийлүүлэгч хариуцна.<br>Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат 1 жил<br>Холтер /бичигчтэй/ 2 жил<br>Ачаалалтай зүрхний цахилгаан бичлэгийн аппарат 3 жил<br>Слит ламп /биомикроскоп/ 2 жил<br>Нүдний хараа шалгах таблиц 1 жил<br>Авторефракто/керетометр 3 жил |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>                                  | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.<br><br>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]  |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br>Хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчтой гэрээ байгуулснаар тухайн багцын үнийн дүнгийн 80 хувийг, захиалагч байгууллага барааг бүрэн хүлээж авсны дараа 20 хувийг нэхэмжлэх, зарлагын падаан болон захиалагч барааг шалгаж хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө.   |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup></b>                  | 9.1. Гэрээний 0.1 хувь: [тоо]<br><br>Гэрээний нийт дүнгийн 10 хувь: [тоо]  |

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>2</sup>

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.